



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/654

Булган сум

**Гэрийн эргэлт хийхэд шаардагдах зардалд
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 4 сумын байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд гэрийн эргэлт хийх ажлыг зохион байгуулсугай.

2. Гэрийн эргэлт хийхэд шаардагдах зардлын 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР